


# ТЭНГЭРЛИГ МЕДИА ГРУПП ЖИЛИЙН ТАЙЛАН 2024





## АГУУЛГА

МЭНДЧИЛГЭЭ

КОМПАНИЙН БҮТЭЦ

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ хороод, тогтоол, ирц

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

ОХИН КОМПАНИ:  
ПРО МЕДИА НЕТВОРК ХХК ҮА ТАЙЛАН  
АНРИД ХХК ҮА ТАЙЛАН

ХАРААТ КОМПАНИ:  
МОНГОЛ ДИФАЙ ХХК ҮА ТАЙЛАН  
МОНГОЛ ТЕЛЕВИЗ ХХК ҮА ТАЙЛАН  
МПЕРС ХХК ҮА ТАЙЛАН  
ОРИ СТУДИОС ХХК ҮА ТАЙЛАН

КОМПАНИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН 2024

МОНГОЛЫН АНХНЫ ОЛОН НИЙТИЙН НЭЭЛТТЭЙ  
ХУВЬЦААТ МЕДИА ХОЛДИНГ КОМПАНИ

## МЭНДЧИЛГЭЭ

Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид, харилцагчид, бизнесийн түншүүд, хамтран ажиллагсад та бүхнийхээ энэ өдрийн амар мэндийг эрье.

Улиран одогч 2024 он ТэнГэрЛиг Медиа Групп ХК-ийн хувьд салбартаа шинийг бүтээсэн, үзэгч, уншигчиддаа үнэ цэнийг бүтээсэн, амжилт бүтээлээр дүүрэн он байлаа.

ТэнГэрЛиг Медиа Групп (MSE: TNGR) нь Монголын хэвлэл мэдээллийн салбарын анхны олон нийтийн буюу нээлттэй хувьцаат компани бөгөөд өргөн зурвасын телевиз, дижитал медиа, сурталчилгаа, эвент зохион байгуулалт, OTT стриминг болон бүтээлч контент үйлдвэрлэл зэрэг чиглэлүүдээр үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд нээлттэй, хувьцаат медиа компани байснаараа олон нийт хэвлэл мэдээллийн компанийг эзэмших, үйл ажиллагаанд нь хяналт тавих, ашиг өгөөжөөс нь хүртэх боломжийг бүрдүүлж мөн цаашлаад хэвлэл мэдээллийн салбарт шинэ жишиг тогтоож, түүгээрээ дамжуулан нийгэмд эерэг өөрчлөлтийг авчрах зорилготой юм.

Бид цар тахлын хүнд нөхцөлд үйл ажиллагаагаа эхлүүлж байсан хэдий ч маш амжилттай бөгөөд хурдтайгаар ажиллан өнгө төрхөө тодорхойлж, бүтэн брэндинг хийн, [www.tngr.media](http://www.tngr.media) албан ёсны вэбсайтаа хийсний сацуу хаалттай хүрээнд 5,941,457 ширхэг хувьцаа нэмж гаргах зөвшөөрлөө Санхүүгийн

зохицуулах хорооноос 2021 оны 09 дүгээр сарын 8-ны өдрийн №344 тоот тогтоолоор авч, нийт хувьцааны 6,000,000 ширхэг байхаар үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулж байсныг онцлуштай.

Түүнээс хойш тогтвортой үйл ажиллагаагаа өргөжүүлсээр, өдгөө бүрэлдэхүүндээ Про медиа нетворк ХХК (TenGer TV), Анрид ХХК (Unread media), Монгол телевиз (Mongol HD), Ори студиос ХХК, Мперс ХХК гэсэн охин болох хараат компаниудыг багтаан ажиллаж байна. Өнгөрсөн жилийн туршид Монголын Хөрөнгийн Бирж дээрх цорын ганц хэвлэл мэдээлэл, медиа чиглэлийн компани болох манай компанийн (MSE:TNGR) нийт 1 тэрбум төгрөгийн 166 мянган ширхэг хувьцаа арилжаалагджээ.

2024 онд Монгол телевизийн хувьд оюуны өмчийн эрхтэй дотоод гадаадын контент, шоу нэвтрүүлгүүдээрээ салбараа түүчээлж, олон улсын стандартад нийцсэн техник, тоног төхөөрөмжийн тусламжтайгаар мэргэшсэн багтай хамтран дотоод, гадаадын кино, контентуудыг үндсэн форматын дагуу бүтээх зорилготой Ори Студиос төсөл амжилттай А блокын барилгаа ашиглалтад оруулж, эвент үйл ажиллагаа зохион байгуулж эхэллээ.

Оригинал, эерэг контентоор дамжуулан дараагийн үеийнхнийг сэтгэлгээний хувьсгалд уриалан дуудах зорилготой Анрид ХХК нь өөрсдийн оригинал контентуудын цар хүрээг улам тэлж салбартаа жишиг



ТУЗ-ийн дарга Г. Уянга

тогтоосон 500-аас дээш оролцогчтой олон эвент, арга хэмжээнүүдийг улирал бүр амжилттай зохион байгууллаа. Ажил хэрэгч, мэдээ мэдээллийн телевиз хэмээх тодотголтой TenGer TV тэнцвэртэй, хараат бус, олон талт агуулга бүхий мэдээллийн хөтөлбөрүүдээ хүргэж, үзэгчдийн итгэл, талархлыг хүлээсэн үнэ цэнийг бүтээж байна. Амжилтаа ахиулсаар ирсэн түүхэн он цагийн хэлхээнд бидэнтэй хамт байсан нийт хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагчид, бизнесийн түншүүд, хамтран ажиллагсад та



Гүйцэтгэх захирал Г. Бат-Эрдэнэ

бүхэндээ сайн сайхан бүхнийг хүсэн ерөөж, 2025 он бидний хувьд дараагийн үсрэнгүй амжилтын жил байх болно гэдэгт итгэл дүүрэн байна.

Хүндэтгэсэн,  
ТУЗ-ийн дарга  
Г. Уянга

Гүйцэтгэх захирал  
Г. Бат-Эрдэнэ

ТэнГэрЛиг Медиа Групп (MSE: TNGR) нь Монголын хэвлэл мэдээллийн салбарын анхны олон нийтийн буюу нээлттэй хувьцаат компани бөгөөд өргөн зурвасын телевиз, дижитал медиа, сурталчилгаа, эвент зохион байгуулалт, OTT стриминг болон бүтээлч контент үйлдвэрлэл зэрэг чиглэлүүдээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Группын бүрэлдэхүүнд одоогийн байдлаар:

Хараат компани: Монгол ТВ, ОриСтудиос, Мперс компаниуд хамаарагдаж буй.

Охин компани: ТэнГэр ТВ, Анрид

Яагаад?

- Нээлттэй, хувьцаат медиа компани байснаараа олон нийт хэвлэл мэдээллийн компанийг эзэмших, үйл ажиллагаанд нь хяналт тавих, ашиг өгөөжөөс нь хүртэх боломжийг бүрдүүлж байгаа. Мөн цаашлаад хэвлэл мэдээллийн салбарт шинэ жишиг тогтоож, түүгээрээ дамжуулан нийгэмд эерэг өөрчлөлтийг авчрах зорилготой юм.

Зорилго

- Монголын медиа салбарын анхны олон нийтийн нээлттэй хувьцаат, ил тод, хараат бус байдлыг хангасан, нэгдмэл редакцын бодлоготой групп компани болох
- Медиа салбарт шинэ жишиг тогтоож, зах зээлийг томсгон, үр нөлөөг ихэсгэж, түүгээрээ дамжуулан нийгмийг эерэг өөрчлөлтөд хөтлөх
- Уламжлалт болон дижитал медиа, OTT, технологийн инновациудыг нэгтгэж, хүн бүрт контентийн боломжит бүх төрлөөр, төхөөрөмжид үл хязгаарлагдан хүрэх


Алсын хараа

Эзэмших ирээдүй. Бүтээх ухамсар.  
(Өөрөө эзэмших ирээдүй. Ирээдүйгээ эзэмш.)


Үнэт зүйлс

- Хараат бус / Independent
- Ил тод, нээлттэй / Transparent
- Бүтээлч / Creative
- Инновацилаг / Innovative
- Хүртээмжтэй / Accessible

## КОМПАНИЙН БҮТЭЦ



## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД, %



|                      |           |
|----------------------|-----------|
| 2022/12/31           |           |
| Нэгжийн хаалтын ханш | 16,900Т   |
| Нийт хувьцаа         | 6,000,000 |
| Нийт үнэлгээ         | 101 тб    |



|                      |           |
|----------------------|-----------|
| 2023/12/31           |           |
| Нэгжийн хаалтын ханш | 10,000Т   |
| Нийт хувьцаа         | 6,000,000 |
| Нийт үнэлгээ         | 60 тб     |



|                      |           |
|----------------------|-----------|
| 2024/12/31           |           |
| Нэгжийн хаалтын ханш | 6,000Т    |
| Нийт хувьцаа         | 6,000,000 |
| Нийт үнэлгээ         | 32 тб     |

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

### ЕРДИЙН ГИШҮҮД



Г.Уянга

#### Боловсролын байдал

- Санхүү Эдийн Засгийн Дээд Сургууль, Банк санхүү
- Хартфорт дээд сургууль, MBA

#### Ажилласан байдал

- Ард Пропертиз ХХК, Гүйцэтгэх захирал
- Арван гэрийн холбоо ХХК, Гүйцэтгэх захирал
- Грасрүүтс жижиг дунд бизнес дэмжих төв (НҮБ-ийн төсөл), Захирал




Г.Бат-Эрдэнэ

#### Боловсролын байдал

- Улс төр нийгэм судлал, Зүүн Англи Норвичийн Их Сургууль
- Удирдах албан тушаалтны хөтөлбөр, Харвард Бизнесийн сургууль

#### Ажилласан байдал

- Монгол Телевиз ХХК, Гүйцэтгэх захирал
- Монголын телевизүүдийн холбоо, УЗ-ийн дарга
- Монгол Телевиз ХХК, Стратеги бодлого төлөвлөлт хариуцсан дэд захирал
- Номсис ХХК, Ерөнхий захирал



Н.Мөнхнасан

#### Боловсролын байдал

- Санхүү эдийн засгийн удирдлага, Сан Францискогийн их сургууль
- Санхүүгийн инженер Магистр, Жорж Вашингтон их сургууль

#### Ажилласан байдал

- Монполимет Групп, ТУЗ-ийн дарга
- Дэлхийн банк төв оффис АНУ, Монгол улсыг хариуцсан эдийн засагч
- Монголбанк, Эдийн засагч
- ANN ХХК, Үүсгэн байгуулагч, Ерөнхий захирал

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

### ЕРДИЙН ГИШҮҮД



Ч.Батхүү

Боловсролын байдал

- Олон улсын харилцаа, Loughborough University
- Ажилласан байдал
- Брикланд ХХК, Ерөнхий захирал



А.Ундрал

Боловсролын байдал

- Эдийн засаг МУИС
- Менежмент магистр, Львений Их сургууль

Ажилласан байдал

- ТэнГэр Телевиз, Гүйцэтгэх захирал
- Анрид ХХК, Гүйцэтгэх захирал
- Монголын үндэсний олимпын хороо, Нарийн бичгийн даргын орлогч
- UBS Телевиз, сэтгүүлч, редактор



Б.Золбоо

Боловсролын байдал

- Олон улсын нягтлан бодох бүртгэл, СЭЗИС
- Эдийн засагч, Plattsburgh коллеж

Ажилласан байдал

- Ард Санхүүгийн Нэгдэл, Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч
- Ард Санхүүгийн Нэгдэл, Санхүү эрхэлсэн захирал
- Ард Менежмент, Гүйцэтгэх захирал
- Ард Менежмент, Хөрөнгө оруулалтын шинжээч
- Ард Секьюритиз УЦК, Хөрөнгө оруулалтын шинжээч

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

### ХАРААТ БУС ГИШҮҮД



В.Ганзориг

Боловсролын байдал

- Бизнесийн удирдлага, ХҮДС
- Бизнесийн удирдлага мастер, Австрали Нотр Дэймийн их сургууль
- Цахим бизнесийн удирдлага мастер, Японы олон улсын их сургууль

Ажилласан байдал

- BSP, УЗ-ийн дарга
- Медиа Групп, Гүйцэтгэх захирал
- Шунхлай Групп, Стратеги хариуцсан захирал



Ж.Алтангүний

Боловсролын байдал

- Бизнесийн удирдлага, Эм Ай Ю
- Бизнесийн удирдлагын магистр, Тайваний үндэсний шинжлэх ухаан технологийн их сургууль

Ажилласан байдал

- Гүйцэтгэх захирал, Монголын Эдийн Засгийн Форум



Б.Наранзун

Боловсролын байдал

- Монгол Улсын Их Сургууль

Ажилласан байдал

- Лето Мьюзик ХХК, Гүйцэтгэх захирал
- АПУ ХК, ОНХХ хариуцсан захирал
- АПУ ХК, ХН хариуцсан захирал
- Шунхлай Групп, ОНХХ хариуцсан захирал

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ хороод

### АУДИТЫН ХОРОО




В.Ганзориг

Ч.Батхүү

Б.Наранзун

### ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, САНХҮҮ ЭРСДЭЛИЙН ХОРОО



Б.Золбоо

Н.Мөнхнасан

А.Ундрал

В.Ганзориг

### ЗАСАГЛАЛ, НЭР ДЭВШҮҮЛЭХ, ЦАЛИН УРАМШУУЛЛЫН ХОРОО



Б.Наранзун

Ж.Алтангүний

Г.Уянга

## УДИРДЛАГЫН БАГ

Г.Бат-Эрдэнэ  
Гүйцэтгэх  
захиралД.Бат-Оюун  
Санхүү эрхэлсэн  
захирал

А.Ундрал

Тэнгэр ТВ, Анрид  
ХХК Гүйцэтгэх  
захирал

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ тогтоол

1  
ээлжит  
хурал

4  
Хороодын  
хурал

7  
Эчнээ санал  
хураалт

11  
Шийдвэрлэсэн  
асуудлын тоо

| Нэр          | Нийт<br>хурлын тоо | Хуралд хамрагдсан<br>байдал | Хувьцааны тоо |
|--------------|--------------------|-----------------------------|---------------|
| Г.Уянга      | 1                  | Биечлэн 1                   | 1,940         |
| Г.Бат-Эрдэнэ | 1                  | Биечлэн 1                   | 832,286       |
| А.Ундрал     | 1                  | Биечлэн 1                   | -             |
| Н.Мөнхнасан  | 1                  | Төлөөлөгч 1                 | 600,000       |
| В.Ганзориг   | 1                  | Цахим 1                     | -             |
| Б.Золбоо     | 1                  | Биечлэн 1                   | 1,065         |
| Ч.Батхүү     | 1                  | Биечлэн 1                   | -             |
| Б.Наранзун   | 1                  | Цахим 1                     | -             |
| Ж.Алтангүний | 1                  | Цахим 1                     | 768           |

## НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

### БИДНИЙ СОНГОЛТ БИДНИЙ ИРЭДҮЙ - МЭТГЭЛЦЭЭН 2024

2024 онд явагдсан УИХ-ын болон орон нутгийн сонгуулийн үеэр “Мэтгэлцээн 2024” цуврал контентийг санаачлан хэрэгжүүлж, үзэгчдээс өндөр үнэлгээ авч, сонгуулийн мэтгэлцээнийг дэмжиж, иргэдэд сонголтоо зөв хийхийг уриаллаа.

#### ТЭРБУМ МОД

TenGer TV нь тогтвортой хөгжлийн үзэл санааг түгээн дэлгэрүүлж, сайн туршлагуудыг хуваалцан хэрэгжүүлэгчдийг алдаршуулах зорилготой “Цэнхэр толбо” мэдээллийн хөтөлбөрийг нэвтрүүлж эхлэв. Энэ хөтөлбөр нь “Тэрбум Мод” сангаас байгаль орчны сайн санаачлагыг дэмжих тэтгэлэгт хөтөлбөрт хэвлэл мэдээллийн сангийн дэмжлэгийг хүртсэн юм.

#### ХҮНСНИЙ ХУВЬСГАЛ ХӨТӨЛБӨР

TenGer TV нь нийгмийн хариуцлагын хүрээнд “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөнийг дэмжин, долоо хоног тутмын эфирээрээ “Хүнсний хувьсгал” нэвтрүүлгийг үнэ төлбөргүйгээр цацлаа.

#### АЛТАН ҮЗЭГ

Сэтгүүл зүйн чиглэлээр суралцаж буй оюутнуудын дунд явагддаг хамгийн том арга хэмжээ “Алтан үзэг 2024” наадамд TenGer TV, Unread Media компаниуд мэдээллийн ивээн тэтгэгчээр ажиллалаа

#### ӨӨРЧЛӨЛТ НЭГ ХҮҮХДЭЭС

6/42 Лотто болон “Veloo foundation” сайн үйлсийн сантай хамтран хүүхдүүдийн ирээдүйг дэмжих, тэдний боловсрол, эрүүл мэндийг сайжруулах хандивын үйл ажиллагааг өрнүүлж байна.

### БОЛОВСРОЛЫН ЭВЕНТ

Unread Media 2018 оноос эхлэн ХААН Банктай хамтран шинэ оюутнуудын хамгийн том цугларалт тодотголтой “Rise” арга хэмжээг зохион байгуулсаар ирсэн. Энэ жилийн арга хэмжээнд TenGer TV мөн нэгдэж, 1000 гаруй оролцогчтойгоор амжилттай зохион байгууллаа.

#### МЕДИА ТҮНШ

Unread Media компани нь нийгмийн эерэг өөрчлөлтийг өртөөлж, залуусын оролцоог нэмэгдүүлэх чиглэлийн арга хэмжээ, төсөл хөтөлбөрүүдийг дэмждэг уламжлалтай. 2024 онд Хүний нөөцийн мэргэжилтнүүд болон талентуудыг холбох гүүр “Talent Summit”, Дата аналит, дата мэргэжилтнүүдэд зориулсан арга хэмжээ “Data Summit”, Медиа мэргэжилтнүүд, сонирхогчид болон олон нийтэд зориулсан талбар “The Media Show” зэрэг шинэ эвентийн цувралуудыг эхлүүлэв. Хамтрагч байгууллагуудын хамтаар зохион байгуулсан уг эвентүүд нь тухайн комьюнитигаас эерэг үнэлгээ авч чадлаа.

#### ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

Unread Media нийтлэлийн бодлогоороо дамжуулан уур амьсгалын өөрчлөлт, тогтвортой хөгжлийн төлөөх үзэл санааг түгээн дэлгэрүүлэх эрхэм зорилготой ажилладаг. Энэ зорилгын хүрээнд ХААН Банктай хамтран бэлтгэдэг 2 долоо хоног тутмын цахим товхимол “2030”-ыг тасралтгүй бэлтгэн хүргэж, байгаль орчны чиглэлийн сайн туршлагуудыг алдаршуулах “Тогтвортой хөгжил” буландаа нийт 50 гаруй нийтлэлийг бичсэн байна.

### МОНГОЛ HD-СОНГОЛТ

Монгол ТВ нь 2024 оны их хурлын сонгуулын ажилтай холбогдуулан Сонгуулийн Ерөнхий Хорооны 11,101 секундын буюу 244 сая төгрөгийн цацалтыг хэвлэл мэдээллийг байгууллагын үүргийн дагуу, Соёл урлагын газрын 10,805 секундын буюу 237 сая төгрөгийн цацалтуудыг цацсан.

#### НҮҮДЭЛ ШИЙДЭЛ-ЭРҮҮЛ МЭНД

Монгол ТВ нь Эрүүл мэндийн яамнаас Монгол Улсын ерөнхийлөгчийн зарлиг хорт зуршилгүй эрүүл ирээдүй хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд “Тамхи үйлдвэрлэлийн хөндлөнгийн оролцооноос хүүхэд өсвөр үеийнхнийг хамгаалцгаая”сэдэвт хэлэлцүүлгийг Нийгмийн хүрээнд үнийн хөнгөлөлт үзүүлж Нүүдэл шийдэл нэвтрүүлгээр оруулсан болно.

#### ЗОЧИН

Монгол ТВ нь Эрүүл мэндийн яамнаас Монгол Улсын ерөнхийлөгчийн зарлиг хорт зуршилгүй эрүүл ирээдүй хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд “Тамхи үйлдвэрлэлийн хөндлөнгийн оролцооноос хүүхэд өсвөр үеийнхнийг хамгаалцгаая”сэдэвт хэлэлцүүлгийг Нийгмийн хүрээнд үнийн хөнгөлөлт үзүүлж Нүүдэл шийдэл нэвтрүүлгээр оруулсан болно. Нийгмийн даатгал болон татварын өөрчлөлтүүдтай холбоотой сэдэв болгон өнөө өглөө хөтөлбөрт 37 зочин оролцсон. МОНГОЛЫН МАРКЕТИНГИЙН ХОЛБОО-НЫ дэд ерөнхийлөгч оролцож холбооны хийж хэрэгжүүлж буй ажлуудын талаар мэдээлэл хүргэсэн.

### ORI STUDIOS-ХАНДИВ

Ургах наран хорооллын 200-р цэцэрлэгийн бяцхан сурагчдад оюуны хөрөнгө оруулалт болгон ном хандивлаж, хүүхдийн боловсрол, танин мэдэхүйд үнэтэй хувь нэмэр орууллаа.

#### ЭРЧИМ ХҮЧ

Ургах наран хорооллын эрчим хүчний дутагдалтай нөхцөл байдлыг шийдвэрлэхийн тулд, өндөр хүчдэлийн эрчим хүчний эх үүсвэрийг авчирч, оршин суугчдын амьдрах орчин, хэрэглээг сайжруулахад бодитой хувь нэмэр үзүүлэв.

#### ВИНТЕР ПАРК

Ерөнхий боловсролын сургуулийн 100 хүүхдэд өвлийн аялал, адал явдлаар дүүрэн дурсамж бүтээх боломж олгон Ори Винтер Паркын тасалбарыг бэлэглэсэн нь хүүхдүүдийн сэтгэл ханамж, баяр баяслыг бадраасан сайхан үйл явдал боллоо.

#### БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН 11-Р ХОРОО

Онцгой бүтээлийг Ори-оос уриатай “Ори Медиа” ХХК нь Баянзүрх дүүргийн 11-р хорооны жилийн тайлангийн үйл ажиллагааг Ори Студи-д амжилттай зохион байгуулахад дэмжлэг үзүүлж, олон нийтийн хамтын ажиллагаа, ил тод байдлыг хангахад хувь нэмрээ орууллаа.



2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ

## ПРО МЕДИА НЕТВОРК ХХК



### Үйл ажиллагааны чиглэл

Бизнес мэдээ, контент үйлдвэрлэл, шууд эфир

### Товч танилцуулга

Бид өөрсдийн шинэлэг, өвөрмөц форматтай нэвтрүүлгүүдээр дамжуулан ялгаатай үзэл бодол, олон талын дуу хоолойг нэгтгэж, хоорондоо ярилцан ойлголцох, мэдээллээ хуваалцах, мэдлэг туршлагаа солилцох боломжийг бүрдүүлсэн нээлттэй амьд харилцааг эрхэмлэн ажилладаг бөгөөд Бизнесийн шударга өрсөлдөөнийг дэмжиж, уур амьсгалын өөрчлөлтөд анхаарал хандуулан, нийгмийн тэгш байдлын төлөөх дуу хоолой болохын сацуу Монголын санхүүгийн зах зээлийн хөгжлийн төлөө зүтгэж, үзэгчдийн соён гэгээрүүлэх эрхэм зорилготой

### Хүний тоо

55+

### Алсын хараа

- Бизнес мэдээллийн гол эх сурвалж байна.
- Телевиз суурьтай медиа брэнд бий болгоно.
- Цаг үеийг мэдэрч, технологиор тэргүүлнэ.
- Нийгмийн тэгш байдлын дуу хоолой болно.

### Контент стратеги

- Гүн рүү шумбана
- Үнэт зүйлсээ эрхэмлэнэ
- Анхаарлыг татна
- Амьд байна
- Олон талт үзэл бодлыг хүндэтгэнэ

АЖИЛ ХЭРЭГЧ МЭДЭЭ МЭДЭЭЛЛИЙН СУВАГ

## ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД



January

Канвон 2024 Залуучуудын өвлийн олимпын наадмыг сурвалжлан, шууд дамжуулав  
“Дүнжингаравын дэлбэрэлт”-ийн үеэр шуурхай мэдээ хүргэлээ



February

“Бүсчилсэн хөгжлийн форум”-ыг шууд дамжуулан хүргэж, телевизүүдэд сигнал хуваалцлаа.  
ХБНГУ-ын ерөнхийлөгчийн айлчлалын тусгай хөтөлбөрийг дамжуулав



March

“Боомтын сэргэлт үндэсний форум”-ыг шууд дамжууллаа.  
Бүсчилсэн хөгжил: Улаанбаатар арга хэмжээний шууд дамжуулалтыг гүйцэтгэлээ.



April

“Монголын багш нарын 8-р их хурал”-ыг шууд дамжууллаа  
“Алтай дамнасан тогтвортой байдлын яриа хэлэлцээ” олон улсын чуулга уулзалтад 2 дахь жилдээ медиа хамтрагчаар ажиллав

## ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД



May

“E-Mongolia 4.0” апп-ын шинэчлэл, нээлтийг дамжуулав  
“Шинжлэх ухааны ажилчдын их хурал”-ыг шууд дамжуулав.  
“Crypto Week” арга хэмжээний хамтрагчаар ажиллав



June

“Egune AI”-ийн нээлтийн ажиллагаал шууд дамжуулав  
“Коломбын төлөвлөгөө байгууллагын хурал” олон улсын хурлыг шууд дамжууллаа



July

“Монголын эдийн засгийн форум 2024”-ийн медиа хамтрагчаар ажиллаж, сигнал дамжуулалт, медиа төвийн ажлыг гүйцэтгэлээ  
Үндэсний их баяр наадмын сигналыг Монгол ТВ-ээс авч дамжуулсан.



August

Парис 2024 олимпын наадмын үеэр нээгдсэн “Mongolia House” төслийн медиа хамтрагчаар ажиллалаа.  
“Зүүн хойд азийн хотын дарга нарын чуулга уулзалт”-ыг шууд дамжууллаа

## ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД



September

Дэлхийн эмэгтэйчүүдийн форумын медиа хамтрагчаар ажиллалаа.  
Дэлхийн эмэгтэйчүүдийн форумын медиа хамтрагчаар ажиллалаа.



October

PMI Institute 2024 арга хэмжээний медиа хамтрагчаар ажиллалаа.

“Парламент 2.0” арга хэмжээний нээлтийн ажиллагааны медиа хамтрагчаар ажиллалаа.



November

“Хөрөнгө оруулагч үндэстэн 2024” арга хэмжээг хамтран зохион байгууллаа.  
“Монголын орон сууцжуулалтын ирээдүй 2024” арга хэмжээг шууд дамжууллаа.  
“Бүсүүдийн хөгжлийн үндэсний чуулган”-ыг шууд дамжууллаа.



December

“Алтан сарнай 2024 наадмын медиа хамтрагчаар ажиллалаа.

“Бөртэ Чоно 2024” наадмыг шууд дамжууллаа.

## ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД



CUNY, Microsoft-ийн хэрэгжүүлсэн “AI Journalism Lab” хөтөлбөрт шалгарлаа.

Time, AP, The Economist зэрэг топ редакцуудын хамтаар AI-ийн медиад үзүүлж буй нөлөө, нэвтрүүлэх шийдлүүд болон хэрэгжүүлэх боломжтой төслийн прототайп дээр ажиллав.

Шинжлэх ухааны комьюнитигийн хамгийн том цугларалт “SciCon 2024” 2 дахь жилдээ амжилттай явагдлаа.

Нийт 1000 гаруй залуус Соёлын төв өргөөнд цугларч, энэ удаагийн арга хэмжээнд 20 гаруй байгууллагатай хамтран ажиллав.

Манай продюсер Д.Дэлгэрзаяа Pulitzer Center-ээс зарласан тэтгэлгийг хүртэж, уур амьсгалын өөрчлөлт монгол малчдад хэрхэн нөлөөлж буй талаарх “Herders at the Edge” / Хүслийн хязгаарт/ нэртэй богино хэмжээний баримтат киног бүтээлээ.

Энэ нь Монгол сэтгүүлчдээс Pulitzer Center-ээс грант хүртсэн анхны тохиолдол боллоо.

## МЭДЭЭ ХӨГЖҮҮЛЭЛТ



### ЗОГСОЛТГҮЙ, ШУУД

Мэдээг “тоосго өрөх” зарчмаар бэлтгэж, зогсолтгүй, шууд, иүү динамик хүртээмжтэй бөгөөд үзүүштэй болгох үүднээс шинэчлэл хийж эхлэв.



### 24/7

Эфирийг 24/7 болгон өргөжүүлж, тасралтгүй байдлыг хангаж ажиллаж эхлэв



### ЗАХ ЗЭЭЛ

Зах зээл, хөрөнгийн захын мэдээг хүргэж ажиллаж байна



2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ

## АНРИД ХХК



### Үйл ажиллагааны чиглэл

Медиа, контент үйлдвэрлэл, эвент зохион байгуулах

### Товч танилцуулга

Unread Media бол оригинал, эерэг контентоор дамжуулан дараагийн үеийнхнийг сэтгэлгээний хувьсгалд уриалан дуудах зорилготой хосолмол медиа стартап юм. Контент гэдэгт бид өгүүлэмж (storytelling), арга хэмжээ (events), коммюнити (community)-г багтаадаг бөгөөд оновчтой агуулга, урамтай хэлбэрээр хэрэглэгчдийг гүнзгий суралцахад, далайцтай сэтгэхэд, илүүг бүтээхэд замчлах нь бидний чин эрмэлзэл.

### Хүний тоо

15+

Үйлдэлд хөтлөх санаанууд. Урам өгөх түүхүүд. Гэрэл тусгах цэгүүд. Гэгээ цацраах дүрүүд. Нарийвчлан харуулах өнцөг. Бүрэн зураглах ойлголт. Таниулах ёстой туршлага. Хүргэх учиртай мэдээлэл. Дэвшилтэт сэтгэлгээний охь. Бадрангуй бодлын оч.

Энэ бүхнийг бид хэрэглэгчдийн сонор, мэлмийд сорчлон хүргэхийг зорьдог. Ингэхдээ контентын бүх л төрөл хэлбэрийг сонгон хамгийн ойлгомжтой, шингээхэд хялбар аргыг ашигладаг билээ.

### Алсын хараа

Залуу мэргэжилтнүүд руу чиглэсэн Монголын тэргүүлэгч медиа байх

Бидний бий болгосон үнэ цэн

Өнгөрсөн 10 жилийн хугацаанд бид шинэ үеийн залуу мэргэжилтнүүдэд зориулан хувь хүний хөгжил, технологи, гарааны бизнесийн орчинд өрнөж буй бүхий л мэдээ мэдээллийг хүргэхээр зорьсоор ирсэн нь Монголын гарааны бизнесийн орчинг төлөвшүүлэн хөгжүүлэхэд багагүй хувь нэмэр болжээ.

Үлгэр жишээ дүрүүд, ажлын арга барилаа төлөвшүүлэх, сурч хөгжих чиглэлээ хайж буй залуу мэргэжилтнүүдэд Unread хэзээд найз нь, хөтөч нь байсаар, болсоор ирсэн нь бидний ажлын гол үнэ цэн юм.

## БҮТЭЭГЧ ХҮМҮҮСТ ЗОРИУЛАВ

НӨЛӨӨЛӨЛ

СТАРТАП, ИННОВАЦЫГ ДЭМЖИВ

Эерэг медиа компанийн хувьд шинэчлэлтийг буухиалж, өөрчлөлтийг бүтээж буй мэргэжилтнүүдийг дэмжиж, тэднийг илүү олон хүнд таниулах үүрэгтэй. Энэ утгаараа Unread Media үүсгэн байгуулагдсан 2015 оноосоо мөс хагалагч, шинийг санаачлагч, тоглоомын дүрмийг эвдэгчид, үүсгэн байгуулагчид болон гарааны бизнес, арга хэмжээ, дэвшилтэт инновацын тухай бичиж, мэдээлсээр ирсэн.

Олны анхааралд тэр бүр өртдөггүй ч урдах ажлаа чанартай хийж байгаа эдгээр чимээгүй баатруудыг алдаршуулах ажлаа 2024 онд ч үргэлжлүүлж, сар тутмын “Онцлох стартапууд”, долоо хоног тутмын “Онцлох бизнес” тэргүүтэй нийтлэлүүдээрээ 30 гаруй бизнесүүдийг онцлов. Мөн “Би хэрхэн ажилладаг вэ?”, “Өртөөлөгчид”, “Журнал” гэсэн булангуудаар 100 орчим дүрийн ажлын арга барил, амьдралын түүхийг өгүүлжээ. “Unread 100” жагсаалтыг танилцуулж, бие даасан вебсайт бүхий интерактив контентыг олон нийтэд хүргэлээ



УРАМ ЗОРИГИЙГ ТҮГЭЭВ

Үйлдэлд хөтлөх санаа түгээж, урам зоригоор цэнэглэх бол Unread-ийн амин сүнс. Бодит түүхээс илүү урам зориг түгээх зүйл үгүй. Энэ онд бид Теслагийн анхны Монгол инженерээс эхлээд нийтийн тээврийн асуудлыг шийдэж буй Орос залуу, Холливүүдийн одуудтай ажилладаг бүсгүй, Эверестийн оргилыг эзэлсэн уулчид, Мюнхенд хүрсэн дуу хоолойны эзэн зэрэг түүхүүдийг хуваацлаа. Эдгээр түүхүүд шинэ үеийн манлайлагчдад хүрч, тэдний урам зоригийг бадраан асаасан гэдэгт эргэлзэхгүй байна.

НӨЛӨӨЛӨЛ

ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛД УРИАЛАВ

“Тогтвортой хөгжлийн зорилгууд” бол хүн төрөлхтний 2030 он гэхэд хийж гүйцэтгэх ёстой “гэрийн даалгавар” юм. Эдгээр зорилгуудыг биелүүлэхийн төлөө хувь хүмүүс, албан байгууллагуудын сайн жишээг бусдад таниулж, мэдээлэл түгээх нь медиа салбарын үүрэг.

Тиймдээ ч энэ гинжин хэлхээнд холбогч, сэдэлжүүлэгч нь байхын тулд бид 2019 онд ХААН Банктай хамтран “Тогтвортой Хөгжил - 2030” цахим товхимлыг эхлүүлсэн билээ. Хоёр долоо хоног тутмын Пүрэв гарагт уншигчдад хүрдэг уг товхимол маань хэдийнээ 12 мянга гаруй захиалагчтай болж, нийтдээ 110 дугаарыг уншигчдад хүргээд байна.



АЛДАЛГҮЙ СОНГО

УИХ-ын сонгуульд зориулан “Алдалгүй сонго” цуврал контентыг бүтээж, залуу мэргэжилтнүүд залуусын сонгуулийн идэвхийг нэмэгдүүлэх, улс төрийн боловсролыг сайжруулах чиглэлд нам, эвслүүдтэй хамтран ажиллалаа.

НИЙТЛЭЛ

2024 оны эцсийн байдлаар нийт 14 буланд 666 нийтлэлийг бэлтгэн хүргэв.

Булан


- Онцлох бизнес /Даваа/
- Techworm /Мягмар/
- Би хэрхэн ажилладаг вэ? /Лхагва/
- Мэдүүштэй /Пүрэв/
- Чөлөөт /Баасан/
- Номын тухай /Бямба/
- 7 хоногийн тойм /Ням/

Шинэ

- Өртөөлөгчид
- Тогтвортой хөгжил
- Тайлбарлах нь
- 10 ертөнц, 10 өнцөг
- Таатай оффис
- Зочинтой булан
- 8 минутын улс төр

## ЭВЕНТ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

2024 онд “Talent Summit”, “Data Summit”, “The Media Show” зэрэг шинэ эвентийн цувралуудыг эхлүүлэв. Хамтрагч байгууллагуудын хамтаар зохион байгуулсан уг эвентүүд нь тухайн комьюнитигаас эерэг үнэлгээ авч чадлаа.



“Хөрөнгө оруулагч үндэстэн 2024” арга хэмжээг Ард Санхүүгийн Нэгдэлтэй хамтран зохион байгууллаа.

## UNREAD WRAPPED

Редакцаас жил бүрийн эцэст гаргадаг тойм нийтлэлүүдийг “Unread Wrapped” гэсэн нэрийн дор нийт 8 сэдэвт гаргалаа.



Хүний нөөцийн  
мэргэжилтнүүд болон  
талентуудыг холбох гүүр



Дата аналит, дата  
мэргэжилтнүүдэд  
зориулсан арга хэмжээ




Медиа мэргэжилтнүүд,  
сонирхогчид болон олон  
нийтэд зориулсан талбар



## СОНИН

Долоо хоног тутмын Unread Today сониныг албан ёсоор эрхлэн гаргаж эхэллээ. Одоогийн байдлаар 22 дугаар, 6-10к хувь хэвлэгдэж, 100 гаруй цэгээр тараагдаж байна. 22 дугаарт 50 гаруй байгууллага, брэнд хамтран ажиллажээ. Сонины идэвхжүүлэлтийг залуус руу чиглэн хийж, тусгайлсан зураг авалт, бичлэгүүдтэйгээр тогтмол хийж байна. Моод эргэлээ, даваа гарагт дандаа гарчигла зэрэг түлхүүр үгсээр идэвхжүүлэлт хийж байна.



Цахимаар захиалж унших боломжийг олгох [www.newspaper.mn](http://www.newspaper.mn) сайтыг ашиглалтанд орууллаа. Одоогийн байдлаар 100 гаруй уншигч уг сайтыг ашиглаж байна. 2025 оны 1-р улиралд идэвхжүүлэх төлөвлөгөөтэй.

Түгээлтийн сувгийг нэмэгдүүлэх тал дээр анхааран ажиллаж байна. Монгол Шуудан ХК-тай хамтран 21 аймагт түгээж буй. Автобус, галт тэрэг, хүргэлт зэрэг бусад сувгуудыг идэвхтэйгээр нэмж байна.



2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ

## МОНГОЛ ДИФАЙ ХХК



### Үйл ажиллагааны чиглэл

Программ хангамжийн үйл ажиллагаа, бизнесийн зөвлөгөө өгөх

### Товч танилцуулга

Монгол Дифай ХХК нь Монгол улсын анхны стэйблкойн (валютын нөөцөөр баталгаажсан үнэ цэнийг энгийн хэрэглээний валюттай аргамжсан криптовалютын төрөл) болох MONT-ыг 2021 оны 10-р сарын 29-ний өдөр зах зээлд гаргаж үйл ажиллагаагаа эхэлсэн. Монгол дифай ХХК нь MONT-ын зах зээлийн нийлүүлэлтийг хянаж, цаашдын хөгжүүлэлт болон интеграц хийх төслүүдийг удирдан чиглүүлэх замаар MONT-ын хэрэглээг олон улсын зах зээлд гаргах зорилготой

### Хүний тоо

3

### Алсын хараа

Крипто, блокчэйн ертөнцийг уламжлалт санхүүгийн ертөнцтэй холбох.

### Эрхэм зорилго

Бид MONT-ын зах зээлийн нийлүүлэлтийг хянаж, цаашдын хөгжүүлэлт болон интеграц хийх төслүүдийг удирдан чиглүүлэх замаар MONT-ын хэрэглээг олон улсын зах зээлд гаргахаар зорин ажиллаж байна.

MONT нь Монгол Төгрөгтэй аргамжсан, Төгрөгийн нөөцөөрөө баталгаажсан стэйблкойн. MONT стэйблкойн нь виртуал хөрөнгө болон бусад валют руу түргэн шуурхай, чөлөөтэй хөрвөж виртуал хөрөнгийн арилжааг хялбарчилна.

## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОНЦЛОХ ТАЙЛАН

Лист хийгдсэн биржүүд:



Үйл ажиллагаагаа эхлүүлснээс хойш idax.exchange, Trade.mn, denode.io, Corex.mn биржүүд дээр лист хийж арилжаалагдаж байна.

## MONT (Mongol Tether)-ийн талаар

MONT нь Монгол Төгрөгтэй аргамжсан, нөөцөөрөө баталгаажсан стэйблкойн

MONT стэйблкойн нь виртуал хөрөнгө болон бусад валют руу түргэн шуурхай, чөлөөтэй хөрвөж виртуал хөрөнгийн арилжааг хялбарчилна.

2024 онд бид stablecoin-ийн тогтвортой байдал, хэрэглээ, зохицуулалтын нийцлийг сайжруулахад анхаарлаа хандуулсан. Үндсэн ажлууд нь системийн шинэчлэл, стратегийн түншлэлүүд, зах зээлийн хамрах хүрээг өргөжүүлэх зэрэгт төвлөрөв.

# 5.77

тэрбум MONT

Зах зээлд эргэлдэж буй хэмжээ

# 100,000+

MONT эзэмшигчид

## 2024 оны гол амжилтууд

- Техникийн Сайжруулалт: Polygon, Ethereum, Solana сүлжээнд ажиллах боломжтойгоор ухаалаг гэрээг шинэчилж, аюулгүй байдал, өргөтгөх чадварыг нэмэгдүүлэв.
- Зохицуулалтын Нийцэл: Санхүүгийн зохицуулалтыг дагаж мөрдөх, лицензийн шаардлагыг хангах ажлыг бэхжүүлэв.
- Хэрэглэгчийн Өсөлт: Хэрэглэгчдийн тоог нэмэгдүүлж, хэтэвчний боломжуудыг өргөжүүлэн хүртээмжийг сайжруулав.
- Бодлогын Оролцоо: Тогтвортой байдлыг дэмжих, салбарын хөгжлийг хангах зорилгоор Парламентын ажлын хэсэгт саналаа хүргүүлэв.

## ХАМТРАН АЖИЛЛАГЧ БАЙГУУЛЛАГУУД

Технологийн хамтрагчид:



Хамтран ажиллаж буй блокчэйн төслүүд:



Хамтран ажиллаж буй финтек байгууллагууд:





2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ

ДЭЛХИЙН ШИЛДЭГ КОНТЕНТУУДЫГ  
НЭГ ДОР ҮЙЛДВЭРЛЭГЧ МОНГОЛЫН АНХНЫ  
АЗИЙН ШИЛДЭГ ТЕЛЕВИЗ



ХАМГИЙН ОЛОН СОЦИАЛ  
ДАГАГЧ, ХАНДАГЧТАЙ ТЕЛЕВИЗ



ХАМГИЙН ОЛОН ЦАГИЙН ШУУД  
ЭФИР НЭВТРҮҮЛДЭГ ТЕЛЕВИЗ



## МОНГОЛ ТЕЛЕВИЗ ХХК



Үйл ажиллагааны чиглэл  
Медиа салбарыг түүчээлэгч Монгол Телевиз

Товч танилцуулга  
“Монгол ТВ” телевиз нь Монголд анх удаа оюуны өмчийн онцгой эрхтэйгээр дотоод гадаадын бүхий л контентуудыг худалдан авч, дуу дүрсний өндөр чанартайгаар үзэгчдэд хүргэхээс гадна дэлхийн томоохон шоу нэвтрүүлгийн форматаар Монголд шоу нэвтрүүлгүүдийг амжилттай бүтээж, Монголын нэвтрүүлгийн стандартад шинэчлэл хийж байна.

Хүний тоо  
131+

- Үнэт зүйл
- Шударга үнэн;
  - Чин сэтгэл;
  - Хичээнгүй зүтгэл;
  - Чанд хариуцлага;

Эрхэм зорилго  
Чанартай, сонирхолтой бүтээлийг ёс зүйг эрхэмлэн туурвиж, түгээж, олон нийтийг соён гэгээрүүлэх замаар нийгэмд эерэг өөрчлөлт бий болгон, салбартаа түүчээлэн тэргүүлж, үнэт өв үлдээнэ.

Алсын хараа  
Уран бүтээлч сэтгэлгээг тэтгэн, бүтээн туурвиж хөгжин чадваржих орчныг бүрдүүлэгч удирдлагатай, мэргэжлийн уран чадвар, чанд хариуцлага бүхий оргилсон эрч хүчтэй, сэтгэл хангалуун бүтээлч хамт олонтой, мэдлэг боловсрол, гоо зүй, ёс зүйг дээдлэн шилдэг технологиор туурвисан бүтээлтэй, ашигтай, итгэлтэй бодит үнэ цэнийг хүртэгч харилцагчтай, тогтвортой ил тод байгууллага байхад оршино.

- Гүн хүндлэл;
- Урам зориг;
- Цог Золбоо;
- Бүтээлч сэтгэлгээ;
- Хөрвөх чадвар;
- Эерэг хандлага

ОЮУНЫГ ТЭТГЭЖ, ЖАРГАЛ БЭЛЭГЛЭНЭ

## ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД




### VOICE KIDS

Монгол ТВ телевиз нь хүүхдүүдийн авьяасыг илрүүлж, хөгжүүлэх зорилгоор дэлхий даяар алдартай "The Voice Kids" шоуны 1-р улирлыг амжилттай зохион байгуулж үндэсний хэмжээний анхны ялагчийг тодрууллаа.

### АРДЫН БУЙДАН

Гэр бүлийн хамгийн үзүүштэй, олон мянган үзэгчдийн хүртээл болсон "Ардын буйдан" нэвтрүүлгийн 17-р улирлыг амжилттай үзэгчдийн хүртээл болголоо.



### 5 НАСТНУУДЫН НУУЦЛАГ ЕРТӨНЦ

5 настнуудын нууцлаг ертөнц нэвтрүүлэг нь Монгол ТВ телевизийн хамгийн сонирхолтой хүүхдийн нэвтрүүлгүүдийн нэг болох тус нэвтрүүлгийн 3-р улиралыг 2024 оны 09-р сарын 15-аас эхлэн үзэгч олондоо хүргэлээ.

### БАЯРЫН ТУСГАЙ ХОНОГИЙН ХӨТӨЛБӨР

"Сар шинийн тусгай хөтөлбөр"-ийг 2024 оны 2-р сарын 9-өөс 12-ны өдрүүдэд, "Баяр наадмын тусгай хөтөлбөр"-ийг 7 дугаар сарын 10-13-ны өдрүүдэд, "Шинэ жилийн тусгай хөтөлбөр"-ийг 12 дугаар сарын 29-31 1 сарын 1-ний өдрүүдэд эфирийн 1 сувгаар болон өөрийн сошиал хуудсуудаар эх орон даяар болон дэлхийд тархан суугаа Монголчууддаа шууд дамжуулан хүргэлээ.



## ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД



### НҮҮДЭЛ ШИЙДЭЛ

Нийгэм, улс төр, эдийн засаг зэрэг бүхий л салбар дахь асуудлуудыг хөндөж, олон талт эх сурвалжид тулгуурлан шийдвэр гаргах түвшинд хүргэх зорилготой хэлэлцүүлгийн нэвтрүүлэг бүтэн 12 жил тасралтгүй хүрч байна

### ХАР ХАЙРЦАГ

Үнэн бодит мэдээллийг хөдөлшгүй баримт нотолгоотойгоор хувь хүн болон албан тушаалтны байр сууриас бэлтгэн хүргэдэг ярилцлагын нэвтрүүлэг нь 2015 оноос эхлэн бүтэн 9 жил тасралтгүй хүрч байна




### КАНДИДАТ

Улс төрийн боловсрол олгох реалити нэвтрүүлгийг Монгол Улсын өнцөг булан бүрээс ёс зүйтэй, нийгмийн бодит төлөөлө болж чадах зорилготой 100 оролцогчийг сонгон шалгаруулж 2024 оны 4 сарын 28-наас 5 сарын 20-ны хооронд үзэгчдийн хүртээл болголоо.

### TERMINAL 1.0

Нийгмийн анхаарал,мэдээлэлд хамгийн ойрхон, үйл явдал онцлох сэдэв, шинэлэг бүхний анхдагч эх сурвалжаар дамжуулан хүргэх, ажлын өдрүүдэд шууд явагдах шинэ төсөл Terminal 1.0 нэвтрүүлэг 2024 оны байдлаар нийт 40120 минут буюу 668 цаг 40 минутын шууд эфир буюу 200 дугаарыг бэлтгэн хүргэлээ



## МПЕРС ХХК



### Үйл ажиллагааны чиглэл

Эд мөнгөний хонжворт сугалаа гаргах тусгай зөвшөөрдийн дагуу (лотто)

### Товч танилцуулга

МПЕРС ХХК нь 2019 онд байгуулагдсан ба 2022 онд эд мөнгөний хонжворт сугалаа гаргах тусгай зөвшөөрөл аван 2022 оны 11 сараас үйл ажиллагаагаа эхлүүлсэн. Бидний зорилго Монголын хамгийн том лотто болох зорилгыг тээн одоогийн байдлаар Монгол ТВ болон Ард Санхүүгийн Нэгдэлийн Ард Апптай хамтран идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна.

### Зорилго

Монгол улсад олон улсын стандартад нийцсэн лоттог нутагшуулах

Хүний тоо 6



2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ

ДЭЛХИЙН ЖИШИГТ НИЙЦСЭН, ОЛОН УЛСЫН  
СТАНДАРТЫН ДАГУУ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ 6/42  
ЛОТТО

## ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ



Нийт 60 тохиролд 20 мянга гаруй харилцагч оролцсон. Борлуулагдсан тасалбар 10 мянга орчим. Нийт мөнгөн дүнгийн шагналыг 2,100 хүн авсан байна. Жакпот ₮440 сая болсон байна. Долоо хоногт дунджаар 4,000 тасалбар зарагдсан.



Апп болон вэб сайтын UI (User Interface) болон UX (User Experience) дизайныг шинэчилж, хэрэглэгчдэд илүү хялбар, эерэг туршлага бий болгохоор анхааран ажиллав. Энэ шинэчлэлт нь хэрэглэгчийн оролцоог нэмэгдүүлж, үйлчлүүлэгчдэд илүү сэтгэл ханамжтай үйлчилгээ үзүүлэх боломж олгоно.



## АРГА ХЭМЖЭЭ



6/42 Лотто болон "Velloo foundation" сайн үйлсийн сантай хамтран хүүхдүүдийн ирээдүйг дэмжих, тэдний боловсрол, эрүүл мэндийг сайжруулах хандивын үйл ажиллагааг өрнүүлж байна.




Бид энэ сард хамтрагч байгууллагууд болон хүндэт харилцагчдадаа зориулан урам зориг өгөх, талархал илэрхийлэх зорилгоор дараах бэлгийг бэлдэн илгээв. Баглаа боодлын сонголт бүрд бидний сэтгэл шингэсэн бөгөөд, бэлэг нь харилцагчдад илүү үнэ цэнтэй, сэтгэл хөдөлмөөр байдлаар хүргэхийг зорьсон билээ.




2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ

АЗИД ТЭРГҮҮЛЭГЧ, ДЭЛХИЙД 29-т  
ЭРЭМБЭЛЭГДЭХ, ОЛОН УЛСЫН ISO TC 36 СТАНДАРТЫН  
КИНО ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЦОГЦОЛБОР



МОНГОЛ СОЁЛ УЛАМЖЛАЛАА СУРТАЛЧИЛАХ, КИНО УРЛАГИЙН  
САЛБАРЫГ ДЭЛХИЙН ТҮВШИНД ГАРГАХ ТӨСӨЛ



## ОРИ СТУДИОС ХХК



Үйл ажиллагааны чиглэл

Бүтээлч үйлдвэрлэл, кино контент, түрээс, эвент

Товч танилцуулга

Бид олон улсын стандартад нийцсэн техник, тоног төхөөрөмжийн тусламжтайгаар мэргэшсэн багтай хамтран дотоод, гадаадын кино, контентуудыг үндсэн форматын дагуу дуу, дүрсний өндөр чанартайгаар бүтээж, үзэгчдэд хүргэх, Монгол соёл, түүх, зан заншлаа дэлхийд сурталчлан таниулах, уран бүтээл туурвиж, үндэсний дархлааг тогтоох зорилготой.

Хүний тоо

14

Ори Студиос төсөл нь эх хэл, түүх, өв соёлоо дээдэлсэн эх оронч үзэлтэй Монгол хүнийг хөгжүүлэх, нийгмийг соён гэгээрүүлэх түүнчлэн үндэсний хэв шинж, үзэл бодол, гүн ухаан, гоо зүй, соёл, амьдралын хэв маягийг харуулсан ОУСтандартад нийцсэн бүтээл туурвих зорилготой кино болон контент үйлдвэрлэгчдийн нэгдсэн медиа хабыг байгуулж, ирээдүй хойч үедээ оюуны өвийг үлдээнэ.

Алсын хараа

Чанартай уран бүтээлээс соён гэгээрэл, мэдлэг, соёлын дархлаа, үнэт зүйлсийг бий болгон бүтээлч соёлыг цогцлооно.

Үнэт зүйлс

- Чанартай бүтээл;
- Чин сэтгэл;
- Ёс зүй;
- Хамтын зүтгэл;
- Үзэгч;
- Оюуны өмч;
- Нийгмийн хариуцлага;
- Төгөлдөршил

ТА ӨӨРИЙН САНААГАА БҮТЭЭЛ БОЛГО  
ОРИ СТУДИОС ЭНЭ БҮГДИЙГ БОЛОМЖТОЙ БОЛГОНО

## ЭВЕНТ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



### ХААН БАНКНЫ "ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН БАЯРЫН" ЭВЕНТ ҮЙЛ АЖИЛЛАГАА

1 тайз  
700+ оролцогч  
2500+ нийт оролцогч  
1 live stream баг  
6 Ори студиос баг




### ХААН БАНКНЫ "ЦЭРГИЙН БАЯРЫН" ЭВЕНТ ҮЙЛ АЖИЛЛАГАА

300+ оролцогч  
3 цагийн хөтөлбөр  
2 Ори студиос баг



### ХААН БАНКНЫ "ХҮҮХДИЙН БАЯРЫН" ЭВЕНТ ҮЙЛ АЖИЛЛАГАА

1 өдөр  
2000+ оролцогч  
6 Ори студиос баг  
20+сайн дурын ажилтан  
25+ Unicorn kids энтертаймент баг



### УЛААНБААТАР ГРУПП ШИНЭ ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

1 өдөр  
243 оролцогч  
35+Ори студиос болон Монгол ТВ баг ажилчид  
1 өдөр  
Ори Студи-д

## ЭВЕНТ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



### АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ ШИНЭ ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

1 өдөр  
286 оролцогч  
35+ Ори студиос болон Монгол ТВ баг ажилчид  
Ори Студи-д




### ОРИ ВИНТЕР ПАРК

11 өдөр  
7000+ оролцогч  
70+ сайн дурын ажилтан  
3276 хүүхэд  
15 үндсэн баг  
Ори Студи-д

## ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТТАЙ ХОЛБООТОЙ



Инвескор  
Капитал ҮЦК



Око Д



Европын сэргээн  
босголт  
хөгжлийн банк



Хаан Банк  
ХХК




Гүнд  
Инвестмент  
ХХК



Би Ди Сек  
ҮЦК ХК




Барс Групп



Очир Ундраа  
ОМЗ ББСБ



Өлкий энд Ко  
капитал ҮЦК



Азийн  
хөгжлийн  
банк



Тэсо  
Корпораци




Капитрон Банк  
ХК

## БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН ЯВЦ

Төсөл нь нийт 3 үе шаттайгаар хэрэгжиж дуусах бөгөөд энэ онд эхний үе шат буюу А блок ашиглалтад орлоо

### А БЛОК



## ГАДНА БОЛОН ДОТОР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ




## 1-Р ДАВХАР ҮҮДНИЙ ХЭСЭГ




## 1-Р ДАВХАР КОРИДОТ

## 2-Р ДАВХАР КОРИДОР



## 3-Р ДАВХАР КОРИДОР

## 4-Р ДАВХАР КОРИДОР



## 5-Р ДАВХАР КОРИДОР

## ГАДНА ТАЛБАЙН ТОХИЖИЛТ



### ОРИ СТУДИОС Барилгын ажил

Дотор засал 1-4-р  
давхар  
/Хэрро дизайн ХХК/

Дотор засал 5-р  
давхар  
/Седарсайт ХХК/

Гадна зам талбайн  
тохижилт  
/Дөрвөн уул  
хайрхан ХХК/

Металл хийц  
угсралт  
/Ган хийц ХХК/

Тавилга захиалга  
угсралт  
/УОР ХХК/

## ДОТОР- ХАЛААХ ХЭРЭГСЭЛ БОЛОН ТОНОГЛОЛ УГСРАЛТ



Студийн гэрэлтүүлэг

Гадна гэрэлтүүлэг


Камер угсралт, суурилуулалт



## ТАЛЕНТ ХАБ ТӨСӨЛ



### ТАЛЕНТ ХАБ ВЭБСАЙТ НЭЭЛТ



ОРИ СТУДИОС вэб сайтын  
нээлтийн хүрээнд  
Монголын кино зөвлөл,  
дотоодын болон гадаад  
урлаг соёлын хүндтэй 10  
гаруй зочдыг уригдан  
оролцсон.

### ТАЛЕНТ ХАБ 'OPEN CASTING'



### ТАЛЕНТ ХАБ уран бүтээлчид

120 >>> 196

8 хүний бүрэлдэхүүнтэй Ори Студиосын  
үндсэн баг болон зургийн баг ажилласан.





“ТЭНГЭРЛИГ МЕДИА ГРУПП” ХК-НИЙ  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД

“ХҮЛЭГТХҮННҮ АУДИТ” ХХК

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 5-р  
хороо, Самбуугийн гудамж, МН тахур, 808 тоот  
Web: [www.hulegthunnu.mn](http://www.hulegthunnu.mn), E-mail: [info@hulegthunnu.mn](mailto:info@hulegthunnu.mn)  
Утас: 70140505, 99100064

2025.04.29 № 25/157  
Танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-г

Мэдэгдэл хүргүүлэх тухай

Эрхэм хүндэт танаа,

“Хүлэгтхүннү аудит” ХХК нь “Тэнгэрлиг медиа групп” ХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тусдаа болон нэгтгэсэн санхүүгийн тайланд аудит хийх А-25/83, А-25/84 тоот гэрээг баталгаажуулан 2025 оны 03 дугаар сарын 28-ний өдөр эх хувиар хүргүүлсэн.

Гэрээний дагуу 2025 оны 04 дүгээр сарын 14-ний өдрөөс аудитын ажлаа Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-ын дагуу горим, сорил төлөвлөхөөс эхлэн ажиллаж байгаа бөгөөд гэрээнд зааснаар 2025 оны 05 сарын 20-ний өдөр ажлаа дуусахаар ажиллаж байгаагаа үүгээр мэдэгдэж байна.

Асууж тодруулах зүйл байвал [info@hulegthunnu.mn](mailto:info@hulegthunnu.mn) болон 99100064 дугаар руу залгаж лавлана уу.

ХҮНДЭТГЭСЭН,

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

ИГҮРРАГЧАА



ТЭНГЭРЛИГ МЕДИА ГРУПП САНХҮҮГИЙН ТАЙЛАН 2024

САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН сая.төг

АУДИТЛАГДААГҮЙ

| Санхүүгийн тайлан / сая.төг                    | 2023   | 2024   | YoY    | YoY %  |
|------------------------------------------------|--------|--------|--------|--------|
| Мөнгөн хөрөнгө                                 | 3      | 1      | (2)    | (67%)  |
| Дансны авлага, Бусад авлага, Татвар НДШ авлага | 88     | 227    | 139    | 158%   |
| Урт хугацаат ХО                                | 16,305 | 16,275 | (30)   | (0.2%) |
| Үндсэн хөрөнгө                                 | 1      | 0,89   | (0,11) | (11%)  |
| Бусад эргэлтийн бус хөрөнгө                    | 2,014  | 2,003  | (11)   | (0.6%) |
| Нийт хөрөнгийн дүн                             | 18,411 | 18,506 | 95     | 0.5%   |
| Дансны болон бусад өглөг                       | 361    | 649    | 288    | 80%    |
| Татвар, НДШ өглөг                              | 255    | 274    | 19     | 7%     |
| Хойшлогдсон татвар өр                          | 1      | 0,16   | (0,84) | (84%)  |
| Урт, богино хугацаат зээл болон хүүгийн өглөг  | -      | -      | -      | -      |
| Бусад богино, урт хугацаат өр                  | 2,521  | 2,514  | (7)    | (0.3%) |
| Эзний өмч                                      | 15,273 | 15,069 | (204)  | (1%)   |
| Өр ба эзний өмчийн дүн                         | 18,411 | 18,506 | 95     | (0.5%) |

ОРЛОГЫН ТАЙЛАН сая.төг

АУДИТЛАГДААГҮЙ

| Орлогын тайлан / сая төг            | 2023 | 2024  | YoY   | YoY %    |
|-------------------------------------|------|-------|-------|----------|
| Үйл ажиллагааны орлого              | 15   | 0.9   | (14)  | (94%)    |
| Бусад орлого                        | -    | -     | -     | -        |
| Нийт зардал                         | 293  | 316   | 23    | 8%       |
| Ерөнхий удирдлагын зардал           | 248  | 314   | 66    | 27%      |
| Борлуулалт, маркетингийн зардал     | -    | -     | -     | -        |
| Санхүүгийн зардал                   | 45   | -     | (45)  | (100%)   |
| Бусад зардал                        | -    | -     | -     | -        |
| Гадаад валютын ханшийн зөрүүний олз | 206  | (2)   | (208) | (101%)   |
| ТАТВАРЫН ӨМНӨХ АШИГ                 | (71) | (315) | (244) | 344%     |
| Татвар                              | (74) | (7)   | 67    | (90%)    |
| АШИГ / АЛДАГДАЛ                     | 3    | (308) | (311) | (10369%) |

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН сая.төг

АУДИТЛАГДААГҮЙ

| Мөнгөн гүйлгээний тайлан / сая төг                | 2023  | 2024  | YoY   | YoY %  |
|---------------------------------------------------|-------|-------|-------|--------|
| Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ                    | 103   | (45)  | (148) | (144%) |
| Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | 74    | 797   | 723   | 977%   |
| Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ         | (179) | (754) | (575) | 321%   |
| Зээлээс хүлээн авсан мөнгө                        | -     | -     | -     | -      |
| Зээл урьдчилгаанд төлсөн мөнгө                    | (179) | (754) | (575) | 321%   |
| Төрөл бүрийн хандив                               | -     | -     | -     | -      |
| Цэвэр мөнгөн гүйлгээ                              | (2)   | (1)   | 1     | (50%)  |
| Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл                   | 5     | 3     | (2)   | (40%)  |
| Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл                  | 3     | 1     | (2)   | (67%)  |



# MSE: TNGR

[www.tngr.media](http://www.tngr.media)